

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын  
Үндэсний зөвлөлийн хуралдааны тэмдэглэл

Үндэсний зөвлөлийн хуралдаан Монгол Улсын Ерөнхий сайдын уулзалтын танхимд 2008 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 17 цаг 30 минутад эхлэв.

Хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд, Үндэсний зөвлөлийн дарга С.Баяр болон Үндэсний зөвлөлийн гишүүд: Сангийн сайд Ч.Улаан, Байгаль орчны сайд Г.Шийлэгдамба, Үндэсний аудитын газрын дарга Л.Жавзмаа, Үндэсний статистикийн газрын дарга П.Бямбацэрэн, Улсын Мэргэжлийн газрын дарга Ц.Шийрэвдамба, Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Батбаяр, Нээлттэй нийгэм форумын гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал, Ил тод сангийн тэргүүн Ц.Ганболд, Хүний эрх хөгжил төвийн тэргүүн Г.Уранцоож, Уул уурхайн ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа, Үйлдвэр, худалдааны сайд Х. Наранхүүг төлөөлж дэд сайд Я. Содбаатар, Уул уурхайн ассоциацийн хүндэт ерөнхийлөгч П.Очирбатыг төлөөлж УУҮА-ийн ерөнхийлөгч Д. Ганболд нар оролцов. Хуралдааны ирц 76.4 хувь байв.

Хуралдаанд мөн Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын ахлах референт Э.Сумъяа, Засгийн газрын хэвлэл мэдээллийн албаны ахлах шинжээч Б.Монхоон, ОҮИТБС-ын Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, Ажлын албаны санхүүгийн ажилтан Т.Хүрэлчимэг нар оролцов.

Хуралдаанаар хэлэлцсэн асуудал:

I. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын хүрээнд 2007 онд хэрэгжүүлсэн ажлын биелэлт.

II. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хүрээнд 2006 оны санхүүгийн жилд Засгийн газарт уул уурхайн 25 компаниас төлсөн бүх материаллаг төлбөр, уул уурхайн компаниудаас Засгийн газрын хүлээн авсан материаллаг орлогуудад аудит хийсэн тухай тайлангийн тухай мэдээлэл

III. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын хүрээнд 2008 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

Хуралдааныг Монгол Улсын Ерөнхий сайд, Үндэсний зөвлөлийн дарга С.Баяр нээж үг хэлэв. Тэрээр та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Өөрт оногдсон үүргийн дагуу ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийн хуралдааныг нээж байна. Энэ зөвлөлийн гишүүдийг албан тушаал зааж томилдог байгаа. Миний хувьд урьд ажиллаж байсан Засгийн газруудын залгамж халааг үргэлжлүүлэх бодолтой байна. Өнөөдөр хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, холбогдох материалыг та бүхэнд хүргүүлсэн байгаа. Ингээд эхний асуудал 2007 оны ажлын төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцье. Зөвлөх та эхэлнэ үү.

**1. Хэлэлцсэн нь:** Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Батбаяр Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын хүрээнд 2007 онд хэрэгжүүлсэн ажлын биелэлтийг танилцуулав. /Танилцуулгыг хавсаргав./

С.Баяр: За энэ асуудалтай холбоотой асуулт байна уу? Асуулт гараагүй болно. Санал байна уу?

Тэгвэл шийдвэрээ дараахь байдлаар гаргая.

**Шийдвэрлэсэн нь:** Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын хүрээнд 2007 онд хэрэгжүүлсэн ажлын дүнтэй танилцав.

С.Баяр: дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё. ОУИТБС-ын Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон аудитын дүнгийн талаар танилцуулна.

**2. Хэлэлцсэн нь:** Австралийн "Крейн Уайт энд Ассоушиетс" компанийн хийсэн тайлангийн талаар Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон танилцуулав. /Танилцуулгыг хавсаргав./

С.Баяр: За гишүүдэд асуух асуулт байна уу?

П.Бямбацэрэн: Аудитын тайланг 2 тал зөвшөөрсөн гэсэн үг үү? Зөрүүг тодруулах уу? Засгийн газрын гаргасан тайланг тааруу болжээ гэж байна. Үүний шалтгаан юу вэ? Маягтуудыг сайжруулах хэрэгтэй гэж байна. Яг аль маягтыг хэлээд байна вэ?, компанийн маягт уу?, Засгийн газрын тайлангийн маягт уу?

Ш.Цолмон: Энэ бол уламжлалт тогтсон хэлбэрийн аудит биш учир талууд зөвшөөрч гарын үсэг зураагүй. Засгийн газрын тайлан дутуу байсан. Компанийнх илүү байсан. Тайлангийн 4 маягт байгаа, үүнээс 1, 2, 3 гэсэн маягтуудыг сайжруулах хэрэгтэй гэж зөвлөсөн. Засгийн газрын тайланд зарим үзүүлэлт дутуу орсон учир компани илүү төлсөн байдалтайгаар зөрүү гарсан байна.

Э.Сумъяа: Тайлангийн маягтад НӨАТ-ыг хасах, гаалийн үйлчилгээний хөлс нэмэх, харин тайлан гаргах зааварыг нарийн боловсруулах хэрэгтэй юм байна. Аудитын дүнгээр 7 төрлийн татвар, төлбөрийн томоохон зөрүү буюу 1 тэрбум төгрөгөөс их үнийн дүнтэй зөрчил гарсан. Аудитын хувьд бага хэмжээний зөрүүг орхиж тодруулаагүй байна. Мөн зарим зөрүүг компани хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдол бий. Томоохон зөрүүний тухайд: тухайлбал АМГТХЭГ-аас хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийг компани тус бүрээр тайлан гаргаагүй, тусгай зөвшөөрлийн дугаараар төлбөрөө гардаг юм байна. Энэ зөрүү 7.7 тэрбум байгаа. Газрын төлбөрийн зөрүү 7.2 тэрбум байгаа, энэ нь орон нутгаас аж ахуйн нэгжийн нэрээр төлбөрийн мэдээ ирээгүй юм байна. Олон нутагт үзүүлсэн хандив, тусламж 3.4 тэрбум байгааг мэдээ авч чадаагүй. Том зөрүүнүүд дотор татварын байгууллагын татвар хураалтын дотоод аргачлал, зохион байгуулалтын асуудлаас үүдэлтэй зөрүүнүүд их байгаа. Нөгөө талаар татвар, төлбөр хураалтын дүн тэдгээрийн төрөл бүрээр мэдээ авдаг, компаниар нарийн заагладаггүй, компаниуд олон төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг зэрэгтэй холбоотой.

Л.Жавзмаа: Би нэг санал хэлье. Аудит хийсэн компани нь Малайз, Австралийн аудитын компаниудын сүлжээ байх шиг байгаа юм. Эдгээр сүлжээнүүд орон оронд ажиллаж байгаа. Монголын аудитын компаниар цаашдаа аудит хийлгэх нь зүйтэй. 17 төслийн 4-т нь монголын аудитын компаниуд оролцсон туршлага бий. Хувийн компаниудын дунд тендер зарлаад хэрэгжүүлж болно.

Я.Содбаатар: Тусгай зөвшөөрөл авахтай холбоотой асуудлаар нэг юм хэлье. Орон нутаг нь бас тусгай зөвшөөрөл авах үед зарим аймаг 1 га талбайн төлбөр 1 ам.доллар гэж тогтоон мөнгө аваад байдаг юмаа. Энэ АМГТХЭГ-аас

өгсөн дүн дотор ороогүй бол бас энэ зөрүүнд нөлөөлөөд л явж байгаа гэж бодож байна.

Ц.Ганболд: Анх удаа аудит хийсэн нь зөв. Энэ тайлан бол олон улсын аудитын шаардлага хангаагүй, анхан шатны баримт дээр шалгалт хийгээгүй. Сангийн яамнаас гаргаж ирүүлсэн тоог компаниас ирүүлсэн тоотой тулгаж нэмж хасаад л тавьчихсан юм. Ийм тоон харьцуулалт хийж тайлан гаргаад 101 мянган ам.доллар авч байгаа юм. Уул нь 101 мянган ам.доллараар арай л өөр юм хийж болох байх. Бид судалсан, 355 компани тайлан гаргах боломжтой, 76 компани 2 мянган төгрөгөөс 1 сая төгрөг төлсөн байсан. Бусад компани 1 саяас дээш төгрөг төлж байгаа. Тухайлбал, 139 компани 500 млрд төгрөгийн татвар, төлбөр төлсөн, үүний 400 млрд нь дангаараа Эрдэнэт төлж байна. Уул уурхайн ихэнх жижиг компаниуд татвар төлдөггүй юм билээ. Ийм компани 73 байгаа. Энэ бол уул уурхайн бүх компаниудын тайланг гаргуулах зайлшгүй шаардлага байна л гэсэн үг. Юм төлдөг арай гайгүй гэсэн 25 компанийн тайлан нь ийм юм гарч байгаа юм чинь юу ч төлдөггүй, тэр компаниудын төлсөн татварыг ил болгох нь яах аргагүй чухал байна. Хамгийн нээлттэй Айвенхоу гэхэд л миний мэдэхээр олборлолт явуулаагүй л баймаар юм, ашиглалтын лицензийн төлбөр гээд юугаа төлсөн гээд байгаа юм бэ?. Мөн нээлттэй компани ч зөрүү гарсан, түүнийг нь нягтлан бодохын бүртгэл, баримтыг үзэлгүй тодруулга хийсэн байна.

ОУИТБС-ын тайланг Дэлхийн банкинд зориулж биш, Монголд хэрэгтэй байдлаар гаргах хэрэгтэй. Дэлхийн банкны зөвлөмж Монголд, амьдрал дээр буухгүй байна. Бид арай гайгүй гэсэн 25 компанийн тухай ярьж байгаа. Тэмдэглэлд нийтэд мэдээлэл гаргахыг Засгийн газрын хэвлэл мэдээллийн алба биш, Сангийн сайд л ярьж байхаар тусгах, уриалга гаргах гэнэ, 2 дахь удаагаа уриалга гаргах юм байна. Энэ хэрэггүй. Бид 2007 он дуусаад 2008 он гарсан байхад 2006 оны тайлан ярьж байна. Цаг их алдаж байна. Киргиз Улс 600000 ам.доллар зарцуулсан, тодорхой үр дүнд хүрээгүй. Аудит нь сонгодог аудит биш, зөвлөх үйлчилгээ юм гэнэ, ийм аудит гэж юу байх вэ? "Алтан дорнод Монгол" компанийн бүртгэлийн систем их муу шүү. Шивээ-Овоо уурхайн орчны талбайг бусад аж ахуйн нэгж авсан шиг Багануур бас тийм болсон. Бид тусгай зөвшөөрлийг бүгдийг нь ил тод болгон хэвлэсэн. Тусгай зөвшөөрөл олголт замбараагүй болсон. "Айвенхоу майнз" компани 100 гаруй тусгай зөвшөөрөлтэй. Үүний 5 нь алт, зэсийн, цаана нь олон тусгай зөвшөөрөл түшиглэсэн нүүрсний том төсөл байгаа.

Санаачилгын гол зорилго бол уул уурхайн компаниуд тэр орон нутагт юу өгөв, ямар байдлаар орон нутаг нь ашиг хүртэв гэдгийг ил болгох үүрэгтэй. Жишээ нь Цайрт минерал байна. Сүхбаатар аймгийн газар нутаг дээр үйл ажиллагаа явуулж 83 тэрбум төгрөгийн ашиг олсон байхад Сүхбаатар аймгийн жилийн төсөв 2 тэрбум төгрөг л байсан одоо 1 ч төгрөгөөр нэмэгдээгүй л байгаа юм. Сангийн яам орлого олохоор нь орон нутагт өгөх татааснаас хасч өгч байна. Монголын төр ТҮЦ-ийн эздийг сайн бүртгэж чаддаг мөртлөө уул уурхайн компаниудаа хянаж чаддаггүй гэдэг нь энэ тайлангаас харагдаж байна. Уул уурхайн мэдээлэл улам нээлттэй болж байна, газрын тос 500 мянган баррель олборлосон, ирэх жил 1 сая баррель болох нээ. Гэтэл нутаг дэвсгэрийг хариуцдаг Дорнод аймгийн төсөвт 1 ч төгрөг ордоггүй, зөвхөн мэдээлэл л авдаг юм байна. Бүтээгдэхүүн хуваах гэрээнд нь тэгээд заачихсан байна. Ашигт малтмалын тухай хуулиар 2 ч төлбөрийн тодорхой хувийг орон нутагт нь өгөхөөр тогтсон, гэтэл түүнийг Сангийн яам хэрэгжүүлэхдээ мөн л татаасанд тооцож олгож байна. Канадын Торонтогийн бирж болон бусад 4 бирж дээр Монголын 20-иод ордыг эзэмшигч компаниуд Монголын

ордын нэрийг барьж хувьцаагаа өрилжаалж байна. Гэтэл үүнээс манай улс ямар ч татвар авахгүй байна. Энэ бүгдийг ил болгох хэрэгтэй байна.

Ш.Цолмон: “Айвенхоу майнз” компанийн талаар би тодруулъя. Энэ бол ашиглалтын биш хайгуулын лицензийн төлбөр шүү. Тайлан дээр андуурсан байна. Залруулга хийе.

До.Ганболд: Энэ зөвлөхийн тайлан бол ямар ч байсан эхний зорилгоо хангасан гэж бодож байна. Энэ зөрүүнүүдийг гаргаж ирж байгаа, энэ зөрүүнүүдийн учрыг олох гээд явж байгаа маань том ололт юм аа. Миний харснаар бүртгэлийн асуудлыг цэгцлэх хэрэгтэй гэж ойлгогдож байна. Энэ 25 компани бол харьцангуй үйл ажиллагаа нь тогтворжсон, нэр хүндтэй газрууд шүү дээ. Эд нар бол орон нутагт далд маягаар хамгийн дэмжлэг үзүүлдэг компаниуд ш дээ. Харин хууль бус үйл ажиллагаа явуулдаг тэр нөхдүүд чинь болохгүй юмаа хаацайлахын тулд хамгийн их далд орлогыг орон нутагт оруулдаг байгаа юм. Энэ 25 компаниас 10 нь манай гишүүн компани байна. Иймд бүртгэлийн системийг нэг мөр болгох хэрэгтэй. Компаниуд илүү бичсэн, Засгийн газар нуусан юм шиг харагдаад байна. Шалтгааныг тодруулах ажил л үлдсэн. Түүнээс Дэлхийн банк тэнэг юм сонгосон гэдэг нь чухал биш. Аудитын компани зорилгоо биелүүлсэн. Хандив гэдэг будлиан гардаг. Энэ 25 компани бол хамгийн бага хандив өгдөг, харин үйл ажиллагаа багатай компаниуд илүү хандив өгдөг, хандивын асуудлыг анхааралдаа авах нь зүйтэй. Компани болгон дээр очиж сонгодог аудит хийнэ гэвэл 25 компани дээр ажиллахад 1 жилд ч багтахгүй. Ажлын хүрээг сайн тооцож зөв мэдээлэлтэй асуудалд хандах хэрэгтэй. Гол нь эдийн засгийн механизмыг зөв тооцож, бүртгэлийн системийг сайжруулах нь зөв.

П.Эрдэнэжаргал: Анхны тайлан ил тод болгоход том алхам, ач холбогдолтой боллоо. Энэ тайлан бол хамгийн анх компани тус бүрээр, хандив тусламжийг оруулж харуулж байгаа ОУИТБС-ын тайлан болж байгаа нь их сайшаалтай байна. Зарим улс 3, 4 жил болж байж тайлангаа гаргасныг бодвол манай улс харьцангуй богино хугацаанд нэлээн дэлгэрэнгүй тайлан гаргаж чаджээ гэж бодож байна. Бусад орон бүх тоог нэгтгээд ганц тоо гаргадаг, тэгвэл манай улс 25 компани бүрээр дэлхийд анх удаа тайлан гаргалаа. Орон нутгийн татвар, төлбөр, хандивыг анх удаа оруулж тайлан гаргалаа. Энэ тайлан бол илүү дэвшилттэй тайлан, бид зөвлөлгөөг нь хэрэгжүүлбэл ирэх жил илүү сайн тайлан гаргах болно.

Н.Алгаа: Зөрүү гарах уу, үгүй юү гэдэг нь чухал биш, аж ахуйн нэгжийн санхүүгийн аудит гэдэг бол тусдаа асуудал. Анхны тайлан гэхэд сайн болжээ. Энэ тайланг бол би шаардлага хангахуйц ач холбогдолтой тайлан болжээ гэж бодож байна. Ямар зөрүү гарав, цаашид гадныхнаар хийлгэх үү, дотоодын аудитаар хийлгэх үү гэдэгт бол асуудал бий. Аймаг, орон нутаг аж ахуйн нэгжийг тусгай зөвшөөрөл авахад манайд ийм данс бий, 100.0-150.0 мянган төгрөг хий гэдэг, машин өгдөг. 25 тэрбум төгрөгийн зөрүү нь бүртгэлийн, маягтын гээд ялгах хэрэгтэй. ОУИТБС санаачлага нь цөөн зүйл дээр төвлөрөх ёстой. Тайланд хэрэглээний татвар орох нь хүндрэл учруулаад байна. Тайлангийн маягтаас хэрэглээний татварыг хасах нь зүйтэй байхаа.

Г.Уранцоож: Энэ тайлан компани тус бүрээр гарсан нь нь их сайшаалтай байна. Орон нутгийн иргэд нь харсан ч гэсэн бас мэдээлэл авахаар байна. 1 асуулт байна. Тайлан гаргаагүй компанийг яах вэ?

Ш.Цолмон: Манай Ажлын албаны хувьд тайлан гаргаагүй компанид янз бүрийн арга хэмжээ авах эрх зүйн боломж байхгүй л дээ. Гэхдээ бид тайланг гаргуулахын тулд уулзаж, утасдаж, бичиг хүргүүлж өөрсдөөс шалтгаалсан бүх л арга хэмжээг авдаг.

Э.Сумъяа: Би нэг нэмэлт хэлчихье. Бид бол тайлан гаргасан 64 компанийхаа тайланг сайжруулж, гаргаагүйг нь 2007 онд нэмж гаргуулна л гэж үзэж байгаа. Иймд 2008 онд энэ тал дээр сургалт, семинар нэлээдийг хийхээр төлөвлөөд байгаа.

До.Ганболд: Би Ц.Ганболдын асуудлыг үргэлжлүүлэх гээд байна. Гэнэтийн ашгийн татвар гарснаар далд байдаг жижиг компаниуд бүүр ч далд орж эдний улсад төлөх ёстой мөнгө өөр газар луу явж байна. Эд нарыг ил болгохгүйгээр бид ил тод байдал гэж ярих хэрэггүй ээ. Үүний тулд янз бүрийн хөшүүрэг л хэрэгтэй л дээ. Хуулиар оногдсон үүргээ Засгийн газар биелүүлэх хэрэгтэй. Ашигт малтмалаас орж байгаа орлогын 30 хувийг нь орон нутагт нь таналгүйгээр төсөв дээр нь нэмэлт болгоод өгчих хэрэгтэй. Орон нутгийнхан газраа ухуулсан ч ухуулаагүй ч адилхан байвал бослого тэмцэл гаргадаг, үл ойлголцол үүсдэг асуудал байнга л гарах болно.

С.Баяр: Тайлан бол учир дутагдалтай байгаа нь бас харагдаж байна. Ер нь гүехэн л харж дээ гэж бодож байна. Бичгийн алдаа ч байна, найруулгын алдаа ч байна. Оргүй байснаас охинтой дээр гэдэг. Ерөнхий дүр зураг харах, юун дээр алдав, юун дээр олов гэдгээ харахад хэрэгтэй тайлан болжээ. Гэхдээ оргүйд орвол бас тайлан гаргачихсан маань сайшаалтай л байна даа. Үндэсний зөвлөлийн гишүүдтэйгээ танилцлаа, та бүхний санал, зөвлөмжүүд дотор бодох юм бас зөндөө байна. Бүртгэлийн талаар ойлголтын зөрүү байна гэдэгтэй санал нэг байна. Яриад байгаа нь өөр байна. Энэ салбарын мэдээллийг бид бүрэн мэдэхгүй байна. Цаашид юу хийх вэ гэвэл оруулж байгаа дүгнэлттэй танилцлаа. Гишүүдийн сэтгэл зовсон байдлаар ярьж байгаа зүйл дээр анхаарах хэрэгтэй. Мөнгө хөрөнгө санхүүжилтийн асуудлаа шийдсэн маань сайн боловч, үр ашигтайгаар зарцуулах тал дээр, сайн тайлан гаргуулах талдээр анхааръя. Дараагийн тайлан ийм байхгүй байх аа. Энэ тал дээр Д.Батбаяр дарга хариуцаж ажиллана биз дээ. Гэхдээ ажил хийсэн хүмүүсийн урамыг хугалахгүй байх хэрэгтэй. Ажил хийж байгаа бол үүнээсээ улам сайжруулах, улам өөр болгох. Дараа асуудлаа хэлэлцэхдээ үүнийг анхаарая. Уриалга бол ач холбогдол багатай. Хийж байгаа ажлаа мэдээлж байя, цаашдаа хийх ажил нэмэгдэнэ. Сэтгэлээр унаад ажлаа зогсоож болохгүй эцсийг нь үзтэл ажиллая. Энэ асуудлын ач холбогдлыг ойлгож байна. Гадныхан асуудлыг зөв хараад туслаад байгаа юм байна. Саяны тайланд гарсан зөрүүг яаж арилгах, ямар арга хэмжээ авахыг Д.Батбаярт даалгаж байна.

Шийдвэрлэсэн нь: 1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын хүрээнд 2006 оны санхүүгийн жилд Засгийн газарт уул уурхайн 25 компаниас төлсөн бүх материаллаг төлбөр, уул уурхайн компаниудаас хүлээн авсан материаллаг орлогуудад аудит хийсэн тухай тайланг зарчмын хувьд дэмжиж, гарсан зөвлөмжүүдийн дагуу үйл ажиллагаагаа эрчимжүүлэхээр тогтов.

2. Тайлангаар тогтоогдсон зөрүүнүүдийг шийдвэрлэх тодорхой арга хэмжээг Үндэсний Зөвлөлийн болон ажлын хэсгийн гишүүдтэй хамтран авч ажиллахыг Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Батбаярт даалгав.

3. Тайлангийн дүн, цаашдын зорилтын талаар нийтэд мэдээлэх арга хэмжээ авахыг Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Батбаярт даалгав.

С. Баяр. Дараагийн асуудалдаа орьё.

**3. Хэлэлцсэн нь:** Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын хүрээнд 2008 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төсөл

Э.Сумъяа танилцуулав. (Төлөвлөгөөний төсөл, товч танилцуулгыг хавсаргав.)

П.Эрдэнэжаргал: Тайлан гаргах хугацааг заавал 3 сарын 31 биш 2-р сарын 15 гэвэл ядаг юм бэ. Эртхэн тайлангаа гаргуулаад, аудитаа эхний хагас жилд хийлгэвэл хугацаа хожих юм биш үү.

Э.Сумъяа: Энэ талаар бодоогүй биш бас бодсон. Гэхдээ ном журмаараа бол компани тайлангаа гаргана, тэгээд санхүүгийн хараат бус аудитаар шалгуулна гэж бодохоор 4 дүгээр сарын 15-нд амжихгүй болчихоод байгаа юм л даа. Ашигт малтмалын тухай хуулийн 48.10-аар 1 дүгээр улиралд тайлан гарах ёстой, цаана нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль гээд аж ахуйн нэгжийн тайлан гаргах, түүнд аудит хийх, хувь нийлүүлэгчдийн хурал зарлаж ногдол ашиг хуваарилах гээд бүгд хугацаатай хуулийн заалтууд бий. Эдгээр хуулийн заалтыг дагахгүй гэхээр тайлангийн тоо аудитаар баталгаажихгүй болно, ногдол ашиг орохгүй болно гээд асуудал гараад байдаг. Уул нь бидэнд ирж байгаа санаачилгын тайлангийн татвар, төлбөрийн дүнгүүд бол аудитаар баталгаажсан аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн тоо байх ёстой гээд заачихсан байдаг юм.

С.Баяр: За төлөвлөгөөн дээр асуулт санал байна уу? Байхгүй бол саналыг тусгаад төлөвлөгөөгөө баталъя.

Шийдвэрлэсэн нь: 1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын хүрээнд 2008 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг зарчмын хувьд дэмжиж, хуралдаан дээр Зөвлөлийн гишүүдээс гаргасан саналыг судалж тусган батлахаар тогтов.

2. Энэ оны тайлангийн ололтыг бататгаж, дутагдлаас сургамж авч Ажлын албанаас зохион байгуулж Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 2007 оны 2 талын тайлан гаргах бэлтгэлийг төлөвлөгөөний дагуу хангах, ялангуяа орон нутгийн түвшинд чиглэсэн сургалт хийх, зөвөлгөө өгөх, Үндэсний зөвлөл болон ажлын хэсгийн гишүүдийг энэ ажилд оролцуулах арга хэмжээ авахыг Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Батбаярт даалгав.

С.Баяр: Хэлэх хэдэн үг байна. Үндэсний зөвлөлийн хуралдаан төлөвлөсөн асуудлаа хэлэлцэж амжилттай дуусгалаа. Зөвлөлийн гишүүд хэлэлцсэн асуудал бүр дээр цаашид анхаарах, энэ ажлыг үр дүнтэй болгоход чиглэсэн санал гаргалаа. Шүүмжлэл ч гарлаа.

“Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага-Монгол Улсын анхдугаар аудитын нэгтгэсэн тайлан” гэсэн энэхүү баримт бичиг нь нэг удаа хэлэлцээд өнгөрөх асуудал биш байна. Энэ тайлан тогтсон журмын дагуу энэхүү

санаачлагын олон улсын байгууллагад манай улсын нэрээр очно. Нэгэнт олон улсын аудитаар хийлгэсэн тул бид засч өөрчлөх юм байхгүй.

Гэхдээ энэхүү тайланд гарсан зөвхөн томоохон 25 компаниас Засгийн газарт төлсөн албан татвар, төлбөр, мөн тэднээс Засгийн газрын хүлээн авсан албан татвар, төлбөрийн тайлангийн хоорондын аудитын зөрүү 25 тэрбум төгрөг байгаа явдал бол бид бүхний санааг зовоосон зүгээр үлдээх асуудал огт биш ээ. Энэ тооны цаана хэн нэгний хайхрамжгүй, хариуцлагагүй үйл ажиллагааны тод жишээ олон байгаа байх. Ингэж дүгнэх үндэслэлийг тайланд тодорхой бичсэн байна. Анхны зөрүү 100 тэрбум шахуу төгрөг байлаа, богино хугацаанд тодруулга хийхэд 25 тэрбум боллоо гэсэн нь ийм дүгнэлт хийхэд хүргэж байна. Нөгөө талаар энэ нь манай санхүүгийн ажилтнуудын мэдлэг чадвар сул дорой, мөн татвар, төлбөр хураалт, түүний дүнг нэгтгэх аргачлалд ч дутуу дулимаг юм бас байгаа тухай тайланд бичсэн байсан.

Тайланд дурдсан зарим томоохон зөрүү газрын төлбөр, орон нутагт өгсөн хандив, тусламж дээр гарсан байна. Үүнийг Засгийн газрыг төлөөлж буй байгууллагууд тайлан мэдээгээ төрөлжүүлж аж ахуйн нэгж бүрийн нэрээр бүрэн гүйцэд авч чадаагүйтэй холбон тайлбарлаж байгаа бололтой. Иймд цаашид орон нутагт үүнийг Сангийн яамныхан тодруулах хэрэгтэй.

Мөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрт их зөрүү гарсан байгаа нь анхаарал татаж байна. Учир шалтгааныг мэргэжлийн байгууллагууд гүнзгийрүүлэн судалж зөрүүг аль болохоор гаргуулахгүй байх талаар шийдвэртэй арга хэмжээ авах шаардлагатай байна. Шаардлагатай бол Авилгалтай тэмцэх газраар ч шалгуулж болно. Цаашдын үйл ажиллагаанд тус нэмэр болох талаас нь авч үзвэл Үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Авилгалтай тэмцэх газрын төлөөлөл оруулж болох юм.

Аудитын тайлангаар гарсан зөрүүг судалж шийдвэрлэх ажлыг Үндэсний зөвлөлийн гишүүн Сангийн сайд Ч.Улаан, Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүү болон бусад сайд, дарга нар хамтран судалж 3 дугаар сарын 1-ний дотор Үндэсний зөвлөлд танилцуулж, дараагийн алхамуудыг хэрэгжүүлэхийг даалгаж байна. Ер нь Сангийн яам болон Үйлдвэр худалдааны яамныхан 3-р сарын 1 гэхэд зөрүүнүүдийнхээ учрыг ол гэсэн Ерөнхий сайдын захирамж гарах нь зөв гэж үзэж байна.

Санаачлагыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Уул уурхайн компаниудаас төрийн байгууллагууд, орон нутгийг хөгжүүлэхэд өгч байгаа хандив тусламжийг үнэн зөвөөр тайлагнуулах, түүнийг нийтэд ил тод болгох ажлыг 2007 оны тайланг энэ онд гаргахдаа анхаарч зохион байгуулах хэрэгтэй байна. Үүнийг ажлын хэсэг, ажлын алба хариуцаж ажиллах ёстой. Энэ чиглэлээр аймаг, нийслэлийн Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга нар ч хариуцлагаа ухамсарлаж идэвх санаачлагатай ажиллах хэрэгтэй.

Санаачлагын ач холбогдол, мөн чанарын талаар, энэ чиглэлээр Ажлын хэсэг, Үндэсний зөвлөлөөс хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, цаашид зохиох ажлын талаар сурталчилгааг тогтмол сайн хийх, үүнд ялангуяа төрийн бус байгууллагатай нягт хамтран ажиллах хэрэгтэй байна. Төрийн бус байгууллагуудын оролцоог ихэсгэж, хөрөнгө санхүүг нь шийдэж өгье.

Санаачлагын хэрэгжилтэд тавих хяналтыг төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс чамлахааргүй хэмжээнд тавьж байгаа, гэвч цаашид улам цэгцтэй, тодорхой хяналт тавигдана гэдгийг анхааруулая.

Хийгдэж байгаа ажил, үйл ажиллагааны талаар зөвлөлийн гишүүдэд заавал хурал гэлгүйгээр мэдээлэл шуурхай өгч байх нь чухал байна. Иймд ажлын хэсэг, ажлын алба үүнд анхаарч ажиллах хэрэгтэй.

Санаачлагын 2007 оны 2 талын тайланг гаргах ажлыг сайтар зохион байгуулах, хянан зохицуулах нь Үндэсний зөвлөлийн үүрэг болж байна.

Энэ оны ажлын төлөвлөгөөний төсөлд гишүүдээс гаргасан саналуудыг тусган баталлаа. Иймд төлөвлөгөөг бэлтгэл сайтай, заасан хугацаанд нь хэрэгжүүлж биелэлтийг Үндэсний зөвлөлийн гишүүдэд болон олон нийтэд тогтмол мэдээлж байя.

Манай Үндэсний зөвлөлийн гишүүд энэхүү асуудалд анхнаас нь хариуцлагатай хандаж, нэр төртэй биелүүлнэ гэдэгт итгэж байна. "Гараа сайн бол бариа сайн" гэдэг үгийг санаж ажиллацгаая.

Хуралдаан хаасныг мэдэгдэе.

Хуралдаан 19 цаг 30 минутад дуусав.

Хуралдааны тэмдэглэлтэй танилцсан:

Ерөнхий сайдын ахлах зөвлөх,  
Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга



Д.Батбаяр

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:  
ОУИТБС-ын Ажлын албаны ажилтан



Т.Хүрэлчимэг